| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний   | 5,600,000.00          | 5,536,100.00                |
| 210803 | Даатгалын үйлчилгээ                                     | 1,655,500.00          | 1,655,500.00                |
| 210807 | Газрын төлбөр                                           | 151,300.00            | 151,300.00                  |
| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                  | <b>3,692,200.00</b>   | <b>3,692,200.00</b>         |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                         | 3,692,200.00          | 3,692,200.00                |
| 213    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                 | <b>49,532,600.00</b>  | <b>49,075,000.00</b>        |
| 2132   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                           | <b>49,532,600.00</b>  | <b>49,075,000.00</b>        |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж     | 49,075,000.00         | 48,643,178.00               |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                 | 457,600.00            | 431,822.00                  |
| III    | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                   | <b>405,255,000.00</b> | <b>404,797,400.00</b>       |
| 31     | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                          | <b>405,255,000.00</b> | <b>404,797,400.00</b>       |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих                                 | 405,255,000.00        | 404,797,400.00              |
| 61     | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                                 | <b>1</b>              | <b>1</b>                    |
| 610001 | Төсвийн байгууллага                                     | 1                     | 1                           |
| 62     | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                 | <b>23</b>             | <b>23</b>                   |
| 620001 | Удирдах ажилтан                                         | 1                     | 1                           |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан                                       | 17                    | 17                          |
| 620003 | Үйлчлэх ажилтан                                         | 5                     | 5                           |
| 65     | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                              | <b>23</b>             | <b>23</b>                   |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)                      | 14                    | 14                          |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)              | 9                     | 9                           |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код         | Үзүүлэлт                                                 | Өмнөх он      | Тайлант он    |
|-------------|----------------------------------------------------------|---------------|---------------|
| <b>II</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                 | 19,678,040.00 | 58,939,449.28 |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     | 19,678,040.00 | 58,939,449.28 |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                   | 19,678,040.00 | 18,688,000.00 |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                  | 11,922,000.00 | 15,718,900.00 |
| 210402      | Тээвэр, шатахуун                                         | 11,922,000.00 | 15,718,900.00 |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                            | 232,000.00    | 1,276,000.00  |
| 210702      | Дотоод албан томилолт                                    | 232,000.00    | 1,276,000.00  |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>  | 7,524,040.00  | 1,693,100.00  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний    | 7,524,040.00  | 1,693,100.00  |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  |               | 40,251,449.28 |
| <b>2133</b> | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                     |               | 40,251,449.28 |
| 213303      | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг  |               | 40,251,449.28 |
| <b>I</b>    | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | 19,671,000.00 | 58,939,449.28 |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                       | 19,671,000.00 | 58,939,449.28 |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан      | 19,671,000.00 |               |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц      |               | 5,000,000.00  |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс |               | 14,000,000.00 |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий  |               | 39,939,449.28 |
| <b>III</b>  | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>          | (7,040.00)    | -             |
| 9           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 7,040.00      | -             |
| 10          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | -             | -             |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

---

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар нь хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийг ханган мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилго тавин хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого, хөтөлбөр, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэн, мал аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэр, хөнгөн, хүнс, хоол үйлдвэр, хоршооны салбарын үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнсээр хангаж төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх төрийн байгууллага юм.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол улсын Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Тариалангийн тухай хууль
- Таримал ургамал үр сортын тухай хууль
- Малын генетик нөөцийн тухай хууль
- Хоршооны тухай хууль
- Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын даргын 2022 оны 4 дүгээр сарын 01- ний өдрийн А/12 дугаар “Байгууллагын дотоод хяналт шалгалтын зөвлөл байгуулж төлөвлөгөө батлах тухай” тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилогдож 4 чиглэлээр 25 ажил төлөвлөсөн байна.

Тус байгууллагын гүйцэтгэл сайжруулах болон дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг байгууллагын төсөв санхүүгийн хууль тогтоомжийг мөрдөж байгаа байдал, дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг, шалган туслах ажлын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар, байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл ашиглалтын талаар, салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийн талаар тайлагнаж ажилласан байна.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт Хүнс, Хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газраас 2022 оны төсвийн гүйцэтгэлтэй танилцан, Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар үүрэг чиглэл өгч мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангасан байна.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар нь Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 2019 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн А/385 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 241,035.4 мянган төгрөгөөр буюу 40,09 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                          | эхний үлдэгдэл   | эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт         |
|-----------------------------------|------------------|------------------|------------------|
| Б                                 | 1                | 2                | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                    | -                | -                | -                |
| Урьдчилгаа                        | 7,200.0          | -                | (7,200.0)        |
| Авлага                            | 2,064.0          | -                | (2,064.0)        |
| Бараа материал                    | 80,638.5         | 81,997.5         | 1,358.9          |
| Нөөцийн бараа                     | -                | -                | -                |
| Үндсэн хөрөнгө                    | 511,286.3        | 760,226.7        | 248,940.5        |
| <b>Нийт хөрөнгө</b>               | <b>601,188.8</b> | <b>842,224.2</b> | <b>241,035.4</b> |
| Өр төлбөр                         | 180.0            | -                | (180.0)          |
| Засгийн газрын хувь оролцоо       | 601,008.8        | 842,224.2        | 241,215.4        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө</b> | <b>601,188.8</b> | <b>842,224.2</b> | <b>241,035.4</b> |

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага 2,064.0 мянган төгрөгөөр урьдчилгаа данс 7,200.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь ажиллагсадтай холбогдсон авлага 1,884.0 мянган төгрөгийн авлагыг шүүхэд шилжүүлэн эвлэрүүлэн зуучлахаар дамжуулж шийдвэрлэсэн, Сангийн яамнаас 180.0 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг авч барагдуулсантай холбоотой байна.

Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 80,638.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 81,997.5 мянган төгрөг буюу 1,358.9 мянган төгрөгөөр өссөн нь Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 10 сарын 19-ны А/320 тоот тушаалаар малын галбир бие цогцсийн хэмжилт хийх 3 төрлийн зоо багажыг 4,040.1 төгрөгөөр нийлүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 511,286.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 760,226.7 мянган төгрөг болж, 248,940.5 мянган төгрөгөөр өссөн нь ХХААХҮЯамнаас 16,274.4 мянган төгрөгийн компьютер, Эм И Си Ти Эс ХХК –аас Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын багцад тусгагдсан Шинэ хөдөө төслийн хүрээнд 162,181.8 мянган төгрөгөөр хадлан тэжээл бэлтгэх иж бүрдэл болох трактор, хаман боогч, үрлүүр, Аймгийн засаг даргын 2022 оны 09 сарын 06-ны А/506 тоот захирамжаар конторын гадна шугам сүлжээний засвар 51,152.5 мянган төгрөг, мөн А/505 тоот захирамжаар байгууллагын дотор халаалтын зардал 54,705.2 мянган төгрөгөөр засварлан үндсэн хөрөнгийн сайжруулалтаар орлого авсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 842,224.2 мянган төгрөг болж 241,215.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 664,424.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуй газрын төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс бууруулан 380,260.2 мянган төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлан ирүүлсэн байна. Тус байгууллагын батлагдсан төсөвт Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийн хүрээнд төсөв хооронд зохицуулалт хийснээр 24,994.8 мянган төгрөгөөр нэмэгдэж 405,225.0 мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг төслийг 284,164.2 мянган төгрөгөөр бууруулан 380,260.2 мянган төгрөгөөр Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас батлан ирүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 405,225.0 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 405,225.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 15,583.7 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 389671.3 мянган төгрөг буюу 96,2 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласнаас цалингийн зардал болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 14,893.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү    | Биелэлт |
|-----|-----------------------|------------|-----------|----------|---------|
| 1   | 70802-80101           | 4,000.0    | 4,000.0   | -        | 100.0   |
| 2   | 70805-80801           | 350,122.4  | 335,060.2 | 15,062.2 | 95.7    |
| 3   | 70805-80802           | 49,532.6   | 49,075.0  | 457.6    | 99.1    |
| 4   | 72101-80101           | 1,600.0    | 1,536.1   | 63.9     | 96.0    |
| Дүн |                       | 405,255.0  | 389,671.3 | 15,583.7 | 96.2    |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 14,000.0 мянган төгрөг буюу ХХААХҮЯ-аас ургацын баланс тогтоох, соёлолтод хүлээж авах ажлын шатахууны зардалд 5,000.0 мянган төгрөг, Хоршооны хөгжлийг дэмжих төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын зардалд Жижиг дунд үйлдвэрийн газрын даргын 2022 оны 06 сарын 21-ны А/65 тоот тушаалаар 3,000.0 мянган төгрөг, Хөдөө аж ахуйн биржээс биржийн үйл ажиллагааг өргөжүүлэх, малын гаралтай түүхий эдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, малчид хоршоодыг биржийн ажиллагаанд оролцуулах ажлыг идэвхжүүлэх зэрэг ажлын судалгааны томилолт шатахууны зардалд 6,000.0 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын 2022 оны 12 сарын 15-ны А/729 тоот захирамжаар зудын байдалд шилжсэн 3 сум болон өвөлжилт хүндэрснээс 14 суманд хүрч ажиллан газар дээр нь мэргэжил арга зүйн зөвлөмж өгч танилцах ажлын хэсгийн томилолт шатахууны зардалд 5,000.0 мянган төгрөгийг тус тус хуваарласан байна. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт

орлого 36,939.5 мянган төгрөг буюу хөнгөлөлттэй олгосон үрийн үнэ нийт 58,939.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар тээвэр, шатахуунд 15,718.9 мянган төгрөг, томилолт 1,276.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 1,693.1 мянган төгрөг, улсын төсөвт 40,251.4 мянган төгрөг татан төвлөрүүлж нийт 58,939.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Хэрэгжих хугацаа      | Хүрэх үр дүн                              | Хэрэгжилтийн явц | /мянган төгрөгөөр/ |            |
|-----|-----------------------|-----------------------|-------------------------------------------|------------------|--------------------|------------|
|     |                       |                       |                                           |                  | Зарцуулах төсөв    | Зарцуулсан |
| 1   | 70802-80101           | 2022.01.01-2022.12.31 | Газар тариалан хөгжүүлэх                  | 100.0            | 4,000.0            | 4,000.0    |
| 2   | 70805-80801           | 2022.01.01-2022.12.32 | Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого | 96.1             | 399,655.0          | 384,135.2  |
| 4   | 72101-80101           | 2022.01.01-2022.12.34 | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих           | 96.0             | 1,600.0            | 1,536.1    |
| Дүн |                       |                       |                                           | 96.2             | 405,255.0          | 389,671.3  |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зөвлөмж өгөгдсөн болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг ХХААХҮЯ-аас баталсан баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг ХХААХҮЯ-аас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны 405,225.0 мянган төгрөгийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 6,078.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,559.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тооцохдоо өмнөх оны батлагдсан төсөвтэй тайлант оны батлагдсан төсвийг харьцуулан дүн шинжилгээ хийхэд 38,026.3 мянган төгрөгөөр батлагдсан төсөв буурсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд мэдээлсэн байдлын хэрэгжилт 100,0%-тай, мэдээллийг хугацаандаа байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дүрэмт хувцас бэлтгэсэн, лицензийн төлбөр урьдчилж төлсөн зэрэг зөрчилд 2 төлбөрийн акт, тооллого зохих журмын дагуу хийгдээгүй, төрийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг зөрчсөн зэрэг зөрчилд 6 албан шаардлага өгөгдсөн байна. Төлбөрийн акт, албан шаардлагыг 100,0 % хэрэгжүүлэн Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 68 тоот албан бичгээр хэрэгжилтийг гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                  | Биелэлт  |                |              |
|-----------------|------------------------|------------------|----------|----------------|--------------|
|                 | Тоо                    | Дүн              | Тоо      | Дүн            | Хувь         |
| Акт             | 2                      | 9,139.0          | 1        | 9,139.0        | 100.0        |
| Албан шаардлага | 6                      | 486,598.4        | 6        | 486,598.4      | 100.0        |
| <b>Нийт дүн</b> | <b>8</b>               | <b>495,737.4</b> | <b>2</b> | <b>1,849.3</b> | <b>100.0</b> |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын зарцуулалтыг нарийвчлан шалгах

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 159,333.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 159,333.8 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Аудитаар нийт 42,875.1 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 42,875.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулганы дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд цахим төлбөрийн баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 33,174.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх зааврын 5.5-д Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг Татварын е-тах системд орж бүртгэсэн эсэхийг сар бүр тооцоо нийлж зөрчлийг давтан гаргахгүй байх

#### 2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын шатахууны зардал өмнөх оноос 9,700.0 мянган төгрөгөөр буюу 60,0 хувиар өссөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл. Хэмнэлтийн бусад арга хэмжээ, 15.2-д Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана, 15.2.3-д сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Улаанбаатар хотод болон аймгийн төвд жийп ангиллын автомашины хэрэглээг хязгаарлах замаар тээвэр шатахууны зардлыг хэмнэж үр дүнд хүрч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| /мянган төгрөгөөр/                                                                                                                           |            |            |                                   |     |                          |            |            |            |              |     |         |     |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|------------|-----------------------------------|-----|--------------------------|------------|------------|------------|--------------|-----|---------|-----|
| Алдааны товч утга                                                                                                                            | Нийт алдаа |            | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |            | Үүнээс     |            |              |     | Зөвлөмж |     |
|                                                                                                                                              |            |            |                                   |     |                          |            | Залруулсан |            | Залруулаагүй |     |         |     |
|                                                                                                                                              | Тоо        | Дүн        | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн        | Тоо        | Дүн        | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| Улсын төсвийн хөрөнгөөр худалдаж авсан хүнсний ногооны үрийн 80 хувийг хөнгөлөлтийг үндсэн хөрөнгө данснаас хассан гарз гэж буруу бүртгэсэн. | 1          | 159,333.80 | -                                 | -   | 1                        | 159,333.80 | 1          | 159,333.80 | -            | -   | -       | -   |
| Дүн                                                                                                                                          | 1          | 159333.8   | -                                 | -   | 1                        | 159333.8   | 1          | 159333.8   | -            | -   | -       | -   |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга                                                                                                                                                                              | Нийт зөрчил |         | /мянган төгрөгөөр/ |   |                 |   |         |         |                                      |   |                                                 |   |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|---------|--------------------|---|-----------------|---|---------|---------|--------------------------------------|---|-------------------------------------------------|---|
|                                                                                                                                                                                                 |             |         | Үүнээс             |   |                 |   |         |         |                                      |   |                                                 |   |
|                                                                                                                                                                                                 | Тоо         | Дүн     | Төлбөрийн акт      |   | Албан шаардлага |   | Зөвлөмж |         | Хариуцлага тооцуулах албан шаардлага |   | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |   |
|                                                                                                                                                                                                 |             |         |                    |   |                 |   |         |         |                                      |   |                                                 |   |
| Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд цахим төлбөрийн баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс зөрүүтэй байна. | 1           | 33174.4 | -                  | - | -               | - | 1       | 33174.4 | -                                    | - | -                                               | - |
| Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу шатахууны зардлыг хэмнэх үүргийг биелүүлээгүй өмнөх оноос шатахууны зардал 9,7 сая төгрөгөөр буюу 60 хувиар өссөн байна.                                        | 1           | 9700.6  | -                  | - | -               | - | 1       | 9700.6  | -                                    | - | -                                               | - |
| Дүн                                                                                                                                                                                             | 2           | 42875.1 | -                  | - | -               | - | 2       | 42875.1 | -                                    | - | -                                               | - |